

Давтан Үнэлгээний Уулзалт: Гэр бүл/Асран Хамгаалагчдын Мэдлэгт

Сурагчийн Нэр:

Огноо:

Давтан Үнэлгээний Уулзалт гэж юу вэ?

Гурван жил тутам (эсвэл шаардлагатай бол эрт) сургууль таны хүүхдийг тусгай боловсрол болон/эсвэл холбогдох үйлчилгээний эрх хангаж буй эсэхийг шалгах үүднээс давтан үнэлгээ явуулах шаардлагатай. Үүнээс өмнө та болон танай сургуулийн баг таны хүүхэд үйлчилгээний эрх хангаж буй хэвээр эсэхийг тодорхойлоход туслах шинэ үнэлгээ (шалгалт, ажиглалт г.м) шаардлагатай эсэхийг шийдэх Давтан Үнэлгээ Төлөвлөх Хурал хийдэг.

Давтан Үнэлгээний Уулзалтад хэн оролцдог вэ?

- Та (Эцэг эх/ асран хамгаалагч)
- Таны хүүхдийн багш (ерөнхий болон тусгай боловсрол)
- Захирал, захирлын туслах эсвэл тэдний томилсон ажилтан
- Хэрэв таны хүүхэд холбогдох үйлчилгээ авч байгаа бол холбогдох үйлчилгээ үзүүлэгчид (Хэл, Хөдөлмөр болон Физик эмчилгээний мэргэжилтэн г.м)
- Сурагч дэмжих Зохицуулагч (SSC)
- Таны хүүхэд (тохиромжтой бол)
- Сургуулийн сэтгэл зүйч
- Сургуулийн нийгмийн ажилтан
- Таны эсвэл сургуулийн урьсан бусад хүмүүс

Бид юу хэлэлцэх вэ?

Уулзалтаар баг:

- Хүүхдийн талаарх бүх мэдээлэл болон хийгдсэн үнэлгээнүүдийг хянах. Таны хүүхдэд үнэлгээ явуулсан ажилтнууд дүгнэлтээ хянаж, нэгтгэн дүгнэнэ.
- Баг цугларсан бүх мэдээллийг, эдгээрийн дотор таны хуваалцсан мэдээллийг харгалзаж үзнэ.
- Эрх тодорхойлох жагсаалт Хуудас -г ашиглаж баг нь танай хүүхэд боловсролд сөргөөр нөлөөлөхүйц нэг болон хэд хэдэн хөгжлийн бэрхшээлтэй гэсэн нөхцөлийг хангаж буй эсэхийг, улмаар хүүхдэд тусгайлан боловсруулсан сургалт шаардлагатай эсэхийг авч үзнэ.

Ямар шийдвэр гаргах вэ?

Баг нь таны хүүхэд тусгай боловсролын үйлчилгээний эрх хангаж буй хэвээр эсэхийг шийдэж, суралцахуйн хөгжлийн бэрхшээл/хөгжлийн бэрхшээлийн мөн чанарыг тодорхойлно.

Эцэг эх/ Асран хамгаалагч Давтан Үнэлгээний Уулзалтад ямар үүрэгтэй вэ?

- Уулзалтын үед яриа хэлэлцүүлэгт идэвхтэй оролцоорой. Жич: Хэрэв танд хэлмэрч ба/эсвэл уулзалтад оролцоход ADA хөнгөлөлт шаардлагатай бол энэ тухайгаа сургуульдаа мэдэгдэнэ үү.
- Өөрийн санаа, бодол, санаа зовоосон асуудлуудаа чөлөөтэй хуваалцаж болно.
- Шаардлагатай бол асуулт асууж, тодруулга аваарай.

Жич: Танай хүүхдийн үйлчилгээний эрхэд өөрчлөлт оруулах, эсвэл тусгай боловсролын үйлчилгээнээс хасахын тулд сургуульд таны зөвшөөрөл шаардлагатай.

Давтан Үнэлгээний Уулзалтад Бэлдэх



Уулзалтад бэлтгэлтэй, өөртөө итгэлтэй очих зарим зөвлөмж:

- ☒ Эцэг эх ярих тайлбараа бичгээр гаргаж багийн гишүүдэд хурлаас өмнө танилцуулах. Эцэг эхийн Мэдээллийн Төв (PRC)-д тайлбар бичих жишээ хуудас байгаа бөгөөд үүнийг авч ашиглаж болно.
- ☒ Хуваалцахыг хүссэн хувийн тайлангаа (жишээ нь, үнэлгээ, эрүүл мэндийн тайлан) эмхэтгэж, хурлаас өмнө урьдчилан илгээнэ үү.
- ☒ Багийн авч үзэж буй хөгжлийн бэрхшээлийн ангилалд хамрагдах ажлын хуудсыг шалгана уу.
- ☒ Үнэлгээний үр дүн бүхий эрх тодорхойлох ажлын багцтай эрх тодорхойлох хурал болохоос наад зах нь хоёр хоногийн өмнө авч танилцах боломжтой. Хурал болохоос наад зах нь хоёр долоо хоногийн өмнө сургуулийнхаа тусгай боловсролын захиргааны туслахтай багцыг хүлээн авах төлөвлөгөөгөө баталгаажуулна уу.
- ☒ Үнэлгээний үр дүнгүүдийг багтаасан давтан үнэлгээний багцыг сайтар хянаж үзэх цаг товлож, цаг зарцуулах.
- ☒ Хуваалцахыг хүссэн сэтгэгдэл/тэмдэглэлээ дараах "Ярилцах Сэдэв" хэсэгт бичнэ үү.
- ☒ Уулзалтын үеэр асуухыг хүссэн асуултуудаа дараах "Асуулт" хэсэгт жагсааж бичнэ үү.
- ☒ Хэрэв танд асуулт байвал эсвэл уулзалтад бэлтгэхэд дэмжлэг хэрэгтэй бол Эцэг Эхчүүдийн Мэдээллийн Төв (PRC)-д хандаарай.
- ☒ Хэрэв та уулзалтад хэн нэгнийг (найз, өмгөөлөгч, гэр бүл г.м) оролцуулахаар төлөвлөж байгаа бол энэ тухайгаа сургуульдаа урьдчилан мэдэгдсэнээр нэмэлт зай, материал бэлтгэх боломжтой юм.

Асуух Асуултууд	Ярилцах Сэдэв /Нэмэлт Асуулт
• Өнөөдрийн уулзалтын хэлэлцүүлэг эсвэл шинэ үнэлгээнээс гарсан мэдээлэл нь манай хүүхдийн одоогийн IEP дэмжлэг/ үйлчилгээнд хэрхэн нөлөөлөх вэ? • Энэ уулзалтаас гарсан шийдвэртэй холбоотой баримт бичгийг би хэзээ хүлээж авах вэ? • Өнөөдрийн уулзалтын үр дүнд санал нийлэхгүй бол би юу хийх вэ?	

ДЭЛГЭРЭНГҮЙ



PRC танд туслахад бэлэн байна.
Бидэнтэй 703.228.7239 утсаар
эсвэл prc@apsva.us хаягаар
холбогдоно уу.



PEATC: Эцэг
Эхийн Эрх



PEATC:
Үнэлгээний Тухай
Ойлголт



VDOE: Давтан
Үнэлгээний тухай
Видео



PEATC:
Давтан Үнэлгээ



PEATC: Bell Curve &
Стандартчилсан
тест